## БИД ЮУ ХЭРЭГЖҮҮЛДЭГ ВЭ?

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар нь төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүдийг удирдлага, зохион байгуулалт, сургалтаар хангаж, үйлчилгээний стандартын шаардлага мөрдүүлэх, иргэдэд цахим ур чадвар олгох болон чиг үүргийнхээ хүрээнд бусад холбогдох ажлыг зохион байгуулж ажилладаг.

Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын системийг ашиглан төрийн үйлчилгээг операторын горимоор хаанаас ч ойрхон хүргэх “ХУРДАН” цэгүүдийг нийслэл, орон нутаг болон хилийн чанадад үе шаттайгаар нээж байна.

“ХУРДАН” цэг нь 43 төрийн байгууллагын 478 төрлийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд үзүүлж байна.

Цаашид 56 төрийн байгууллагын 785 төрлийн үйлчилгээг үзүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

### ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ ТӨРӨЛ


Операторын горим


ТҮЦ,
Киоск машин


Веб сууръ


Гар утас /Хөдөлгөөнт төхөөрөмжийн аппликейшн/

Тун удахгүй


Метаверс

**“ХУРДАН” ЦЭГИЙН САЛБАРУУД**:

- Нийслэлд 48 цэг;
- Орон нутагт 81 цэг;
- Хилийн чанадад 29 улсын 44 цэг;
- Хилийн боомтод 1 цэг нийт 174 цэгээр дамжуулан хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.